

**АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2022.01.05

Бүрд сум

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Байгууллагын үнэлгээ	Аймгийн үнэлгээ
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр					
1	1.1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг тус тус аймаг орон нутагт хангуулах, төрийн байгууллагын удирдлагын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх.	1.1.1.Аймгийн Засаг даргаас Төсвийн шууд захирагч нартай байгуулах гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг тооцох.	Аймгийн засаг дарга, сумын засаг дарга нарын гэрээнд тусгагдсаны дагуу “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнг тооцох талаар тусгагдсан. Үүний дагуу эхний хагас жилийн биелэлтийг тооцон аймгийн ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.	100	
		1.1.2.Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн чиглэлээр Сумдын Засаг даргын Тамгын газар, 21 агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН байгууллагын удирдах албан тушаалтнуудыг арга зүйгээр хангаж, нийт мэдүүлэг гаргагч нарын 2021 оны шинэчлэн гаргах хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж, холбогдох мэдээг тайланг АТГ-т хүргүүлэх.	ЗДТГ ын ЭБАТ-ын эрхээр шинээр болон шинэчлэн гаргасан 8 албан тушаалтан ХАСХОМ гаргасан. Мөн 2021 онд шинээр томилогдсон 4 албан тушаалтан 2000* -ээр ХАСХОМ-оо гаргасан байгаа. Тайланг хугацаанд нь аймгийн ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.	100	
		1.1.3.АТҮХөтөлбөрийн төлөвлөгөөг 19 сум, 23 агентлагт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт, үр дүнг тооцох.	-	-	

		1.1.4.Аймгийн АТҮХөтөлбөрийн 2021 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дүнг Авлигатай тэмцэх газарт нь тайлагнах.	-	-	
2	1.2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, төрийн албан хаагчдын АТГазраас зохион байгуулах сургалтад хамруулах.	1.2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны дотор ХЭЗХэлтэс нь нэгтгэн, 25-ны дотор АТГазарт хүргүүлэх.	-	-	
		1.2.2.АТГазраас зохион байгуулдаг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулах.	АТГ-аас 10 дугаар сарын 18-д зохион байгуулсан “Өвөрхангай аймгийн авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, авлигын нөхцөл байдал 2020-2021” сургалтанд Засаг дарга, ИТХ-ын дарга, Тамгын газрын дарга нар хамрагдлаа. Мөн Авлигын эсрэг үндэсний чуулган, 2021.12.23-ны өдөр зохион байгуулсан ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулахтай холбоотой бэлтгэлийг хангуулах зорилгоор мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах Эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-уудын сургалтанд Тамгын газрын ЭБАТ , авилга ашиг сонрихлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нийтийн албанд шинээр томилогдсон албан тушаалтануудад зорицлан 11 дүгээр сарын 12-д зохион байгуулсан цахим сургалтанд шинээр томилогдсон 5 багийн засаг дарга, байгууллагын дарга нар тус тус хамрагдав.	100	
		1.2.3.Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан, иргэд хүүхэд залуучуудад хүргэх үйл ажиллагааг АТГазар болон аймгийн БСУГ-тай хамтран шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнах.	Байгууллагын дарга нар болон Тамгын газрын албан хаагчдад Авилга ашиг сонирхолын зөрчил, авилгаас урьдчилан сэргийлэх сэдвээр 25 албан хаагчдад сургалт зохион байгуулсан	70	

3	1.3.Төрийн байгууллагын удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх.	1.3.1.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаанд тодорхой төсөв, хөрөнгө төлөвлөн зарцуулах.	ЗДТГ-ын төсөвт веб сайтны төлбөр тусгагдсан. Сайтыг тогтмол ажиллуулж байна.	100	
		1.3.2.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилга, уриа аянд нэгдэх.	-	-	
		1.3.3. Төрийн байгууллага хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын хооронд байгуулсан гэрээнүүдэд / ихэвчлэн худалдан авалт/ авилгаас ангид байх асуудлыг тусган ажиллаж байна.	70	
4	1.4. Авлига ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авч ,	1.4.1.Авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр шинэ шийдэл, сайн туршлага, дэвшилтэд технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах (Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх)	Иргэд харьяалал харгалзахгүй хаанаас ч төрийн үйлчилгээг нэг дороос авах нөхцөл бүрдэж Нийгмийн халамжийн 9 үйлчилгээ цахимд шилжиж давхардсан тоогоор 550 хүн хамрагдсан. Мөн операторын үйлчилгээнээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа, нийгмийн даатгалын лавлагаа, Цагдаагийн байгууллагын тодорхойлолт, жолооны үнэмлэх, иргэний үнэмлэхний лавлагаа зэргийг 36 хүнд олгосон байна.	100	
Дундаж оноо				91,4	
Хоёр. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн данс ны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудад заасан төрийн байгууллага, түүний удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр хүлээсэн нийтлэг үүрэг.					
5	2.1. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1. Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн	2.1.1.Үйл ажиллагаандаа ашиглаж буй аймгийн албан ёсны цахим хуудас www.uvurkhangai.mn сайтад, хэлэлцэгдэж буй хууль, шийдвэрийн төслийг байршуулж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн зүгээс санал, хүсэлт илэрхийлэх бололцоог бүрдүүлэх.	-	-	

	төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах.	2.1.2.Иргэд олон нийт, санал, хүсэлт илэрхийлэх бүлгүүдтэй санал солилцож, гаргасан санал хүсэлтийг хүлээн авах.	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад 57 иргэнээс саналыг сонсож тусгасан . Мөн сумын ИТХ, аймгийн Либерал оюуны сан"-тай хамтран Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны төсвийн гүйцэтгэлд төсвийн хяналтын сонсгол зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд оролцогч 4, ажиглагч 20, дуудагдаж ирсэн албан тушаалтан 5, зохион байгуулагч 3 бүгд 32 хүн оролцов. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр 2022 онд хийгдэх төсөл хөтөлбөр арга хэмжээнүүдэд иргэдээс санал авч багийн иргэдийн хурлаар хэлэлцүүлэн , жагсаалтыг ажлын хэсэг эрэмблэн засаг даргад өргөн бариад байна.	100	
		2.1.3.Аймгийн ЗДТГазрын бодлогын хэлтсүүд болон сум, агентлагууд хийж хэрэгжүүлсэн ажлаа тухай бүр байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах.	Сумын вейб сайтад цаг үеийн мэдээ 14, ил тод цэсэнд 11, бодлогын баримт бичиг 1-ийг тус тус байршуулсан.	100	
6	2.2. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. Төрийн байгууллага Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах.	2.2.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк твиттер, youtube суваг) мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг боломжит бүхий л хэлбэрээр иргэд олон нийтэд хүргэх.	АТГ-ын “Олон нийтийн төв”-ийн Өнөөдөр “ашиг” олж байгаа мэт санагдавч #авлигын хор уршгийг бүх нийтээрээ төлдөг... Бусдын #боломжийг_бүү_хулгайл! , Авлигаас хэн ч хождоггүй..., Үнэний ҮНЭ үгүй болсон энэ цагт Үүргээ ухамсарлан ТА шүглээ ҮЛЭЭ... #110 #ШүглээҮлээ #ИлчилжАВАР зэрэг контентууд, 10 дугаар сарын 11-ны мэдээлэл, #Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа #110 #Гомдол_мэдээлэл_хүлээн_авах_утас, #Зөв_зөвд_шударга_зөв зурагт хуудас зэргийг Өвөрхангай аймгийн Бүрд сумын албан ёсны пейж хуудсаар дамжуулан нийтэд мэдээлсэн.	100	

		2.2.2. АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар, нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.	-	-	
		2.2.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар, булан ажиллуулах.	-	-	
		2.2.4. Байгууллагын цахим хуудсанд авлигын эсрэг үйл ажиллагааны урд оны тайлан, 2021 оны төлөвлөгөө, иргэд болон хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад зориулсан шаардлагатай гарын авлага, тараах материал бусад мэдээллийг бэлтгэн байршуулж, тогтмол шинэчлэх.	Burd.ov.gov.mn сайтад авилгын эсрэг үйл ажиллагааны 2020 оны тайлан, авлигын эсрэг үйл ажиллагаа, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээний 2021 оны төлөвлөгөө, түүний эхний хагас жилийн биелэлт зэргийг байршуулсан.	100	
7	2.3. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3. Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах.	2.3.1. Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах.	Бүрд сумын ЗДТГ, Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль, удирдах дээд байгууллагуудын тогтоол шийдвэр, заавар, журмуудын хэрэгжилтийг шалгаж үнэлэлт дүгнэлт өгсөн. Дээрх шалгалтын танилцуулга, албан шаардлага, түүний биелэлтийг сумын вэб сайтад мэдээлсэн.	100	

8	2.4. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх.	2.4.1. Тухайн жилийн төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 4 дүгээр сарын 1-ний дотор, дараа жилийн төсвийн төслийг 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн эцсийн санхүүгийн тайлан болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 5 дугаар сарын 1-ний дотор, төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг өөрчлөлт орсон өдрөөс хойш 14 хоногийн дотор тус тус цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах.	Төсвийн 6 байгууллага 30 мэдээ хуулийн хугацаанд байршуулахаас 29 мэдээг хуулийн хугацаанд байршуулж хүүхдийн цэцэрлэг 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хугацаа хоцруулан байршуулсан байна	100	
---	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----	--

		<p>2.4.2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)</p>	<p>ИТХурал орлогын 3 гүйлгээ, ЗДТГ зарын орлогын 18 гүйлгээ, нэмэлт санхүүжилтын дансны 2 зарлагын таван сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг тухай бүрт нь хугацаанд нь шилэн дансны цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан болно.</p> <p>ЭМТ Цалингийн зардлаас бусад 5000000 төгрөгний орлого санхүүжилт эхний 10 сарын байдлаар 309280,1 мян төг үндсэн дансаар, нэмэлт санхүүжилтээр ажилчдад нэг удаагийн тэтгэмж урамшуулал 30 сая төг, илүү цагийн хөлс- 7472,5 мян төг, ковид-19 вакцины санхүүжилт 2 удаа 11365,0 мян төг, хэвтэн эмчлүүлэгсэдийн санхүүжилт 4 удаа 30749,0 мян төгрөгийн орлогыг тухай бүр нь infoshilendans.gov.mn сайтад болон байгууллагын мэдээллийн самбараар мэдээллэсэн байна.Зарлагын гүйлгээ гараагүй.</p> <p>ЕБСургууль нь дулаан халаалттай сард таван саяас дээш гүйлгээ гардаг ба бусад зардалд таван саяас дээш гүйлгээ гардаггүй байна. 2021оны 3 дугаар улирлын байдлаар 541985,8 мянган төгрөгийн санхүүжилт авч халаалтын зардалд нийт 66759,9 мянган төгрөгийн 6 удаагийн гүйлгээг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулж мэдээлсэн</p> <p>Хүүхдийн цэцэрлэг 2021оны 3 дугаар улирлын байдлаар 186724,9 мянган төгрөгийн санхүүжилт авч 3 дугаар улирлын тайланд үнэн зөвөөр тусгасан байна.5 сая-ээс дээш дүнтэй зарлагын гүйлгээ хийгдээгү .</p>	100	
--	--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----	--

		<p>2.4.3. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох. (татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл) Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарын хамт мэдээлэх.</p>	<p>Хагас жилийн орлогын мэдээ, Малын тоо, толгойн албан татварын хувь хэмжээг тогтоосон ИТХ-ын тогтоол, малын тоо толгойн албан татварын талаарх зурагт мэдээлэл, Галт зэвсгийн албан татварын хувь хэмжээ, төлөх хуулийн хугацаа цагдаагийн бүртгэл зэргийн талаарх мэдээлэлийг сумын цахим хуудсанд байршуулж сумын хандалт ихтэй фэйсбүүк группүүдэд тухай бүр түгээж ажиллаж байна. Улс, аймаг, орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг татвар төлөгч, татварын төрөл бүрээр хуваарилан Татварын Удирдлагын нэгдсэн системд шивж оруулан сарчилсан төлөвлөгөөний дагуу иргэн, аж ахуй нэгжүүдээ татварт хамруулж байна. Татварын орлогын төлөвлөгөө өссөн дүнгээр 10 дугаар сарын 21-ний байдлаар сумын төсөв 544%-ийн биелэлттэй, аймгийн төсөв 98% биелэлттэй, Улсын төсөв 152%-ийн биелэлттэй байна. Татварын бус орлогын төлөвлөгөө 228%-ийн биелэлттэй байна. Сар бүрийн орлогын мэдээг сумын төрийн сантай нийлэн засаг даргаар батлуулан аймгийн төрийн сан, татварын хэлтэсд хүргүүлэн тухай бүр шилэн дансанд байршуулж байна. Мөн 3 улирлын байдлаарх татварын орлогын мэдээг байгууллагын веб сайт болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.</p>	100	
--	--	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----	--

		<p>2.4.4. Хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Хагас, бүтэн жилээр)</p>	<p>ЗДТГ Ковидтой холбоотой иргэд байгууллагаас ирсэн хандив тусламжийн хөрөнгийн хэмжээ зарцуулалтыг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулсан , мөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хандив тусламжийн орлого ,зарцуулалтын дэлгэрэнгүй тайланг бэлтгэж тайлагнасан болно. Мөн жагсаалтыг ил тод нээлттэй байдлын самбар, бүрд сумын албан ёсны пейж хуудсанд байршуулсан.</p> <p>ЭМТ Хандив тусламжийн орлого бараа материал 32019,7 мян төг, бэлэн мөнгө 1230,0 мян төгрөг, зөөврийн компьютер өгснийг infoshilendans.gov.mn сайт байгууллагын фейсбүк групп болон байгууллагын мэдээллийн самбараар мэдээллэсэн байна.</p> <p>ЕБсургууль Тус сургуулийн ахмад багш Л.Гомбожавын үр хүүхдүүд Монгол хэлний кабинетийг 32700,0 мян.төгрөгөөр тохижуулж өгсөн. Байгууллагын хөрөнгийн бүртгэлд орлогот авч infoshilendans.gov.mn сайт болон мэдээллийн ил тод байдлын самбарт байршуулсан.</p> <p>Хүүхдийн цэцэрлэг 3-р багийн малчин П. Очирсүрэн 500,0 мян.төгрөгийн ширээ өгснийг орлогот авч infoshilendans.gov.mn сайт болон мэдээллийн ил тод байдлын самбарт байршуулсан.</p>	100	
		<p>2.4.5. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр (тухай бүр)</p>	<p>Хөрөнгө зарцуулсан тухай ЗДТГ 7, ЕБС 2 шийдвэрийг Shilendans.mn сайтад байршуулсан.</p>	100	

9	2.5. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5. Тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах.	2.5.1.“Аймгийн худалдаа, үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”, бүрдүүлэх материал, тусгай зөвшөөрөл олгосон иргэн, аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулах.	Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа 5 тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрийн хугацаа дууссан байсныг ажлын хэсэг шалгалт хийж материалыг аймаг руу хүргүүлснээр 5-уулаа тусгай зөвшөөрөл нь сунгагдсан. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын судалгааг сумын веб сайтад байршуулсан.	100	
		2.5.2.Эрүүл мэнд болон боловсролын салбарын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбогдох хууль, журам болон тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, олгосон тусгай зөвшөөрөл зэргийг тус тус сайтад байршуулж, нийтэд мэдээлэх.	-	-	
		2.5.3.Уул уурхай, байгаль орчин, газрын харилцааны салбарт олгогдож байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой хууль, журам болон тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, олгосон тусгай зөвшөөрөл зэргийг тус тус сайтад байршуулж, нийтэд мэдээлэх.	-	-	
10	2.6. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх.	2.6.1.(Аймгийн Засаг даргын захирамжийн нууцад хамааруулснаас бусад) болон бусад төрийн байгууллага удирдлагаас гаргасан шийдвэрийг байгууллагын цахим хуудаст байршуулж, нийтэд ил тод мэдээлэх.	-	-	
		2.6.2.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж (хуульчилсан акт) дүрэм, журам, заавар болон төлбөрт үйлчилгээний жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах.	Сумын цахим хуудасны “Ил тод байдал” цэсэнд төлбөрт үйлчилгээ буланд төлбөрт үйлчилгээний жагсаалтыг байршуулсан.	100	

11	2.7. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх.	2.7.1.Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл өбóбóаé хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр), шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын мэдээллийг талаарх мэдээлэл	Өргөдөл гомдлын 1,2,3,4 -р улирлын мэдээг сумын цахим хуудсанд байршуулсан. 100%	100	
		2.7.2.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийн хүлээн авч уулзах цагийн хуваарийг ил тод мэдээлэх.	Захидал харилцаа хариуцсан ажилтаны мэдээллийг ил тод нээлттэй байдлын самбар, веб сайтад байршуулсан.	100	
		2.7.3.Нэгж, ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн талаарх мэдээллийг байшруулах, өөрчилж шинэчлэгдсэн нөхцөлд тухай бүр нь шинэчлэх.	ЗДТГ-ын мэргэжилтэнүүдийн албан тушаалын тодорхойлолтыг сумын вейб сайтад байршуулсан.	100	
12	2.8. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй.	2.8.1.Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, хугацаатай албан бичгийн биелэлтийг заасан хугацаанд нь хүргүүлэх, зөвлөмжтэй холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээ авах.	Аймгийн хууль эрх зүйн хэлтсээс ирүүлсэн хугацаатай албан бичгийг хугацаанд хариуг хүргүүлсэн.	100	
		2.8.2.Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдэл болон хууль, журмын хүрээнд хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн албан бичгийн биелэлтийг тус тус шийдвэрлэн хугацаанд нь хүргүүлэх.	Байхгүй	-	
13	2.9. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл	2.9.1.Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу хянаж, хүчингүй болгох буюу өөрчилнө.	Байхгүй	-	

	боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу дахин хянаж хүчингүй болгох буюу өөрчилнө.	2.9.2.Сумдын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын даргын тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянах, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг хүчингүй болгуулах болон аймгийн Засаг даргын захирамжаар тус тус хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэх.	Эхний хагас жилийн 70 ш захирамж, 10 тушаалыг аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст хянуулсан .Зөрчил дутагдал гараагүй болно.	100	
14	2.10. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10-22 дугаар зүйлүүдэд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах.	2.10.1.Хуулийн 10 дугаар зүйлийн 10-22 дугаар зүйлүүдэд заасан албан тушаалтанд тавигдах 13 төрлийн хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарч, албан тушаалтны ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалтанд зөвлөмж чиглэл хүргүүлж ажиллах.	Шинээр томилогдохоо 8 иргэний АТГ-т хянуулж дүгнэлтийг шинээр томилогдсон албан тушаалтан бүрт өөрсдөд нь танилцуулж зөрчил дутагдал гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллахыг зөвлөсөн.	100	
		2.10.2.Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг /шинэчлэн болон шинээр томилогдсон албан тушаалтнуудын/ үнэн зөв, хуульд заасан хугацаанд гаргуулах, бүртгэх, хянах, үйл ажиллагаа зохион байгуулах.	2 дугаар сарын 15-ны дотор 8 албан тушаалтан ХАСХОМ-оо шинэчлэн гаргасан Шинээр томилогдсон 3 албан тушаалтан хуулийн хугацаанд шинээр ХАСХОМ гаргасан.	100	
		2.10.3.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, цахим системд бүртгэх.	Нийтийн албан томилогдсон 9 хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн цахим санд мэдээлсэн. Үүнээс хянагдаж ирсэн 9 хүний мэдээллийг сумын веб сайтад байршуулсан. Мөн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн Сумын засаг дарга, Тамгын газрын дарга, ЕБС-ийн захирал зэрэг албан тушаалтануудын 118 мэдэгдэл тайлбарыг iaac.mn- д шивсэн.	100	
	Дундаж оноо			100	
<p>Хоёр. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн аймаг, орон нутагт хамаарах 25 заалтын хүрээнд (Сум, агентлагт хамаарах) Зорилт 1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх.</p>					

15	3.1.Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх.	3.1.1.Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх.	ЗДТГ-т 2021 онд төрийн албаны ерөнхий шалгалтанд тэнцсэн 2 хүний туршилтын хугацаагаар томилсон.	100	
		3.1.2.Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг тухай бүрд олон нийтэд ил тод болгох.	2021 онд томилогдсон 9 хүний ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг сумын веб сайтад байршуулсан.	100	
		3.1.3.Төрийн жинхэнэ албан тушаалаас төрийн жинхэнэ албаны нөөцөд байх үндэслэлээр түр чөлөөлөгдсөн, чөлөөлөгдсөн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох.	Тус суманд байгаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтаны сул чөлөөтэй байгаа 6 ажлын байрны захиалгыг аймгийн ТАЗ-д хүргүүлэн, тусгай шалгалт зарласан. Тусгай шалгалтын талаарх мэдээллийг сумын албан ёсны пейж хуудсанд байршуулсан.	100	
		3.1.4.Хүний нөөцийн стратеги, хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлыг хангах, холбогдох хууль тогтоомжийг сайтад байршуулан олон нийтийг танилцах боломжоор хангах.	-	-	
		3.1.5.Сул орон тооны зар болон байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан, ил тод байдлыг хангаж ажиллах.	Тус сумын ЗДТГ-т 6 , ЕБС-ийн 2 сул орон тоог сумын пейж хуудас, сургуулийн олон нийтийн сүлжээ, байгууллагуудын мэдээллийн самбар дээр байршуулж ажиллаж байна. Сумын ЗДТГ-ын орон тоог баталсан аймгийн засаг даргын захирамжийг сумын веб сайтад байршуулсан.	100	

16	3.2.Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах, нийтийн албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх.	3.2.1.Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах.	Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт онлайн сургалтанд Төрийн захиргааны албан хаагчид, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтанууд 16 хүн хамрагдаад байна. Мөн Удирдлагын академаас зохион байгуулсан “Алсын хараа 2050” сургалтанд Тамгын газрын дарга Б.Гачмаа хамрагдаж сертификат авсан.	100	
		3.2.2.Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.	Удирлагын академиас зохион байгуулсан “Алсын хараа—2050” богино хугацааны сургалтанд 1, туслах түшмэлийн мэргэшүүлэх сургалтанд 1 хүн тус тус хамрагдсан.	100	
17	3.3. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	3.3.1.Ёс зүйн дүрмийг ил тод байршуулах.	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг сумын веб сайт, байгууллагын ил тод байдлын самбарт байршуулсан.	100	
		3.3.2. Төрийн байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх.	Төрийн байгууллагуудын ёс зүйн хороонууд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	70	
		3.3.3.Төрийн байгууллагуудын дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих.	Байгууллага бүр дээр дотоод хяналтын нэгж байгуулагдсан. Төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.	30	
18	3.4. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх.	3.4.1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах.	-	-	

19	3.5. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх.	3.5.1.Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох.	-	-	
20	3.6.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.	3.6.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх.	-	-	
		3.6.2.Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх.	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн биелэлтийг тооцон аймгийн ХШҮДАХ-т хүргүүлсэн.		70
21	3.7. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх.	3.7.1.Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах. (бүтэн жилээр,сар бүр)	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг Шилэн дансны нэгдсэн 9 мэдээ байршуулахаас 5 мэдээг хугацаанд нь 3 нь хугацаа хоцорч, 1 сарыг мэдээлээгүй байна.	30	
		3.7.2.Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг бүтэн жилээр болон сар бүр байршуулж мэдээлэх.	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг бүтэн жилээр болон сар бүр байршуулж мэдээлэх ажлыг 9 удаа мэдээлэхээс 6-г нь хугацаанд нь, 2-ийг нь хугацаа хоцроож, 1-ийг мэдээлгүй байна.	30	
		3.7.3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр шивж мэдээлсэн байх.	Нийтийн албан тушаалтан 2 албан хаагчийн 118 ш мэдэгдэл тайлбарыг iaас.mn- д шивсэн.	100	

22	3.8. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлага тооцох, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх.	3.8.1.Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах.	2020 оны ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлд төсвийн хяналтын нийтийн сонсгол зохион байгуулсан. 2022 оны төсвийн батлахаас өмнө 12 дугаар сард төсвийн төсөлд хэлэлцүүлэг зохион байгуулсан.	70	
		3.8.2.Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn , www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх.	2022 оны төсвийн батлахаас өмнө 12 дугаар сарын эхээр хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд тухайн үед нь мэдээллийн хэрэгслээр зарлаж ард иргэдээс санал авна.	70	
		3.8.3.Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас төрийн байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх.	Ийм тохиолдол гараагүй байна.	-	
23	3.9. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх.	3.9.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулах	Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг шилэн дансны сайтад байршуулсан	100	
		3.9.2.Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг байршуулах (хагас, бүтэн жил)	Худалдан авах ажиллагааны хагас жилийн тайланг байршуулсан .	100	
		3.9.3.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах.	Төрийн худалдан авах ажиллагааны цахим сайт tender.gov.mn сайтын үр дүн хэсэгт 8 тендерийн үр дүнг мэдээлсэн. Мөн сумын веб сайтад мэдээлсэн.	100	
		3.9.4.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг тухай бүр байршуулж мэдээлэх.	7 тендерийг цахимаар зарлаж тендерийн баримт бичиг , урилгыг байршуулсан.	100	
		3.9.5.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулж мэдээлэх.	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг засаг даргын албан бичгээр оролцогч нарт тухай бүр мэдээлсэн. Мөн веб сайт, цахим хуудсанд байршуулж мэдээлсэн.	100	

		3.9.6.Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (тухай бүр)	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим сайт болон сумын веб сайтад мэдээлсэн	100	
24	3.10. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.	3.10.1.Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр өрсөлдөгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах, ёс суртахуунтай, өрсөлдөөнт орчин бүхий бизнесийг дэмжин хөгжүүлэх.	Хамааралгүй	-	
25	3.11.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх.	3.11.1.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлж, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх.	Ахмад настанд үзүүлэх төрийн зарим үйлчилгээг сумын ахмадын хороогоор гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажилладаг. 2021 онд ахмадын хороонд 1400,0 мян.төгийн санхүүжилт олгосон байна. Мөн сумын Ахмадын хороо 22 ахмад настануудад өдрийн үйлчилгээ үзүүлж байна. Ахмадын байранд байгаа чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжөөр 78 ахмад настан үйлчлүүлсэн байна.	100	
		Дундаж оноо		85	
		Бүгд оноо		92,1	

Хүснэгт-2

д/д	Төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэсэн ажлын төрөл	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тоо баримтаар товч дурьдах		
1	Сум, байгууллагын албан ёсны ямар вэб сайтад авлигын эсрэг хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, мэдээ, мэдээлэл, жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг байршуулсан талаар /цахим хуудас хаяг нэр/	http://burd.ov.gov.mn/		
2	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гаргасан шийдвэр /тоо/			
3	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө	450		
4	Зохион байгуулсан цахим сургалтын тоо	1		
5	Зохион байгуулсан танхимын сургалтын тоо	2		
6	Цахим болон танхимын сургалтанд хамрагдсан удирдах албан тушаалтан, төрийн албан хаагч, иргэдийн тоо	1.удирдах албан тушаалтны тоо 8 2.төрийн албан хаагчийн тоо 25 3. иргэдийн тоо Нийт тоо 33		
7	Авлигын хууль тогтоомжийн чиглэлээр тараасан гарын авлага, тараах материалын тоо			
8	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулага, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг материал г.м/	Бүрд сумын албан ёсны пейж хуудас, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ олон нийтийн сүлжээ зэргээ дамжуулан авилгын эсрэг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан.		
9	АТҮхэтөлбөр болон Авлигын эсрэг үйл ажиллагаан жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарсан өөрчлөлт, ач холбогдол, үр дүн			

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН/Б.ГАЧМАА /
 ХЯНАСАН:
 ДАРГА...../ М.МӨНХБАЯР/

-ооо-

